



Schweizerische Eidgenossenschaft  
Confédération suisse  
Confederazione Svizzera  
Confederaziun svizra

Swiss Agency for Development  
and Cooperation SDC  
Швейцарийн хөгжлийн агентлаг

# ЖИЛИЙН ТАЙЛАН 2015

ШВЕЙЦАРИЙН ХӨГЖЛИЙН АГЕНТЛАГ МОНГОЛД



## **Жилийн тайлан 2015**

### **Швейцарийн хөгжлийн агентлаг**

#### **Швейцарийн ЭСЯ-ны Хамтын ажиллагааны газар**

Скай Плаза бизнес төв  
Олимпийн гудамж 12, 1-р хороо,  
Сүхбаатар дүүрэг,  
Улаанбаатар,  
Монгол Улс

Ш/х 37  
Улаанбаатар 14210  
Монгол улс

Утас: 976 11 331422  
Факс: 976 11 331420  
Э-шуудан: ulaanbaatar@eda.admin.ch

Вэб: [www.eda.admin.ch/mongolia](http://www.eda.admin.ch/mongolia)

#### **Гэрэл зураг & Эх бэлтгэл**

Швейцарийн хөгжлийн агентлаг  
Интерпресс ХХК

Зураг © Швейцарийн хөгжлийн агентлаг/Д.Давааням

#### **Хэвлэлт**

Интерпресс ХХК

© SDC 2016



Schweizerische Eidgenossenschaft  
Confédération suisse  
Confederazione Svizzera  
Confederaziun svizra

Swiss Agency for Development  
and Cooperation SDC  
Швейцарийн хөгжлийн агентлаг

# ЖИЛИЙН ТАЙЛАН 2015

ШВЕЙЦАРИЙН ХӨГЖЛИЙН АГЕНТЛАГ МОНГОЛД

## Агуулга

Удиртгал	4
2015 оны онцлох үр дүн	5
■ Хөдөө аж, ахуй хүнсний аюулгүй байдлын чиглэлээр	7
■ Мэргэжлийн боловсрол, сургалтын чиглэлээр	11
■ Захиргааны шинэтгэл, орон нутгийн засаглал, иргэний оролцооны чиглэлээр	15
■ Бичил уурхайн салбарт	19
2016 оны хөтөлбөрийн төлөвлөлт	22

# Удиртгал

Он гарахаас хоёр сарын өмнө Шинэчлэлийн Засгийн газрыг огцруулах шийдвэрийг Улсын Их Хурлын чуулганаар гаргасан нь улс төрийн намуудын эвслийг задрахад хүргэв. Ардчилсан нам (АН) Монгол Ардын Нам (МАН)-тай хамтарч, Шийдлийн Засгийн газрыг байгуулсан ч 2015 оны наймдугаар сард МАН-ын зургаан сайдыг огцрууллаа. Ингэснээр АН МАХН, МҮАН-ын хамтарсан “Шударга ёс” эвсэлтэй хамтран Засгийн газраа дахин байгуулав. Улсын эдийн засагт томоохон хөрөнгө оруулалт болох Оюу Толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын төсөл 2015 онд улс төрийн халуун сэдэв байлаа.

Монгол улсын эдийн засгийн өсөлт 2015 онд саарлаа. Энэ нь дэлхийн зах зээл дээр бүтээгдэхүүний үнэ унаж байгаатай холбоотой гэж үзэж байна. Хөрөнгө оруулагчдад зориулсан хууль эрх зүйн зохицуулалт нь савалгаатай, таатай бус байгаагаас гадаадын шууд хөрөнгө оруулалт зогсонги байдалд орсон. Оюу толгойн

## Монгол улсын эдийн засгийн өсөлт

2014 6.9%

2015 3%

уурхайтай холбоотой маргааныг удтал хэлэлцэн шийдвэрлэснээр далд уурхайн таван тэрбум ам.долларын төсөл хэрэгжих боломжтой боллоо. Гэсэн ч экспортын орлого буурч, өртөг ихтэй татаасын хөтөлбөрүүдээс шалтгаалсан улсын өр нэмэгдэн, улмаар Монгол улс төлбөрийн тэнцлийн хямралын ирмэгт тулж ирээд байна. Энэхүү хямрал нь 2016 оны төгсгөл үе хүртэл үргэлжлэх төлөвтэй.

Монгол улс гадаад харилцаандаа олон талт болон гуравдагч хөршийн бодлогоо тогтвортой баримталсаар байна. Мөн тогтвортой ардчиллыг цогцлоосон гэдгээ нотолж, анхны ардчилсан сонгууль, байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тэмдэглэн, Европын аюулгүй байдал хамтын ажиллагааны байгууллагын хурлыг нийслэл хотноо зохион байгуулж, байнгын төвийг сахисан улс гэдгээ олон улсад тунхаглав.



2013-2017 онд Монгол улсад хэрэгжүүлэх Швейцарийн хамтын ажиллагааны стратегийн гол зорилго нь тус орны эдийн засаг, нийгмийн эрх тэгш, тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулах юм. Энэхүү зорилгынхоо хүрээнд:

- Хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдал (ХАА);
- Мэргэжлийн боловсрол, сургалт (МБС);
- Захиргааны шинэтгэл, орон нутгийн засаглал, иргэний оролцоо (Засаглал) гэсэн гурван үндсэн чиглэлээр ажиллаж байна.

Түүнчлэн, ШХА-ийн Монгол дахь хөтөлбөр нь бичил уурхайн салбарт ч хамтарч байгаа. Мөн Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамнаас хэрэгжүүлж буй Тогтвортой хөгжлийн боловсролын хөтөлбөрт дэмжлэг үзүүлж байна.

# 2015 ОНЫ ОНЦЛОХ ҮР ДҮН



## Хөдөө аж, ахуй хүнсний аюулгүй байдлын чиглэлээр:

- Монгол орны бэлчээрийн төлөв байдлын үнэлгээний үндэсний тайланг эцэслэн танилцуулж, малын бэлчээрийг талхагдлаас сэргийлэх гол арга бол зохистой ашиглалт гэж дүгнэсэн юм. Үүний үр дүнд Засгийн газар малчидтай байгуулах бэлчээр ашиглалтын гэрээний талаар шинээр боловсруулж буй Бэлчээрийн тухай хуульд тусгалаа.
- Малчдын бэлчээр нутгаа зүй зохистой ашиглах уламжлалт арга технологийг хөхүүлэн дэмжих зорилго бүхий Бэлчээр ашиглагчдын хэсэг (БАХ)-үүдийн зохион байгуулалтыг нэвтрүүлж буй Ногоон алт төсөл Милан 2015 Экспо үзэсгэлэнгээс байгалийн нөөцийн тогтвортой менежментийн тэргүүн туршлагын шагнал хүртлээ.
- Ногоон алт төсөл болон БАХ-ийн хамтарсан Дундын сангаас нийт 15,000 малчин өрхөд хэрэглээний зээл олгосноор орлого багатай, эмзэг бүлгийн малчин өрхүүдэд байнгын тулгардаг бэлэн мөнгөний хомсдлыг шийдвэрлэхэд тусалж байна.
- УИХ-д өргөн барьсан “Мал, амьтны эрүүл мэндийн тухай” хуулийн төсөл нь мал аж ахуйн салбарт гарсан чухал дэвшил болов. Монгол улсын нутаг дэвсгэрт мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангах, нийтийн эрүүл мэндийг хамгаалах, худалдааны чөлөөт байдлыг дэмжихтэй холбоотой харилцааг уг хуулиар зохицуулах юм.



## Мэргэжлийн боловсрол, сургалтын чиглэлээр:

- МБС-ын салбарт хэрэгжүүлж буй төслүүдийн үр дүнд баруун бүст ажлын байраар хангагдсан МБС-ын төгсөгчдийн хувь эрс нэмэгдлээ. Тухайлбал, төслийн сонгогдсон мэргэжлээр төгсөгчдийн 60—аас дээш хувь нь сургууль дүүргэснээс хойш зургаан сарын дотор ажлын байртай болсон нь улсын дундаж болох 48 хувиас илүү байна.
- Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх үйлчилгээг сайжруулснаар үйлчилгээ хүртэгчдийн 75 хувь нь мэргэжлээ сонгохдоо зөв шийдвэр гаргах дэмжлэгийг хүртэв.
- 2015 онд улсын хэмжээнд, өсвөр насныханд зориулсан долоон эмнэлэгт нийт 39,000 гаруй залуус үйлчлүүлжээ.





### **Захиргааны шинэтгэл, орон нутгийн засаглал, иргэний оролцооны чиглэлээр:**


- Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаагаар төрийн захиргааны үйлчилгээний хүртээмж, үр дүн тогтмол сайжирч байна. Орон нутгийн санаачлага, хөрөнгөөр нэг цонхны үйлчилгээний 152 төвийг байгуулав.
- Орон нутгийн түвшинд шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог хангах суурь үндэс нийт сумдад бий боллоо. Иргэдийн нийтийн хурлын ирц 14 хувиар нэмэгдэн, хариуцлагын тогтолцоо сайжрав.
- Нутгийн удирдлагын байгууллагууд төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй болгох, шийдвэр гаргах явцад иргэдийн оролцоог хангах болон иргэдийн өмнө ажлаа хариуцан тайлагнахад суралцаж, чадавхи нь бэхжиж байна.
- Монгол улсад төвлөрлийг сааруулах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх бодлого, эрх зүйн орчинг бэхжүүлэх суурь бий боллоо.



### **Бичил уурхайн салбарт:**

- 15,000 гаруй бичил уурхай эрхлэгч эрүүл мэнд, нийгмийн даатгалын үйлчилгээ хүртэж, 1300 бичил уурхайчид төрөөс санхүүжүүлсэн ажлын байрны аюулгүй байдал, эрүүл мэндийн үзлэгт хамрагдлаа.
- Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлал нь Бичил уурхайн үйл ажиллагааг зохицуулах 308 тогтоолын хавсралт болно.
- Тогтвортой бичил уурхай (ТБУ) төслийн эерэг үр дүн, сайн туршлагуудыг гадаад ертөнцөд түгээн таниулснаар Монгол улс бичил уурхайн мэдлэгийн төв хэмээн олон улсад хүлээн зөвшөөрөгдлөө.

Хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдал



Швейцарийн хөгжлийн агентлаг нь бэлчээрийн зохистой менежмент, малын эрүүл мэндийг сайжруулах, төмс, хүнсний ногооны үрийн үйлдвэрлэлийг дэмжих замаар Монгол улсын хөдөө аж ахуйн салбарын хөгжилд хувь нэмрээ оруулж байна.



# Хөтөлбөрийн үр дүн



Малчид бэлчээрээ зохистой ашиглах зорилгоор сайн дураар өөр хоорондоо нэгдэж байна.

Бэлчээр ашиглагчдын хэсэг (БАХ) гэдэг нь дөрвөн улирлын бэлчээрээ хамтдаа ашиглаж ирсэн, хөрш зэргэлдээ нутагладаг, бэлчээрээ зохистой ашиглах зорилгоор нэгдсэнээр хамтын зохион байгуулалтанд орсон малчин өрхүүдийн сайн дурын нэгдэл юм. Ногоон алт төслөөс санаачилсан энэхүү ажлын хүрээнд өнөөдрийн байдлаар нийт 1,100 БАХ төвийн болон баруун бүсийн долоон аймагт орон нутгийн засаг захиргаатай хамтран боловсруулсан бэлчээр ашиглалтын гэрээ, мал аж ахуйн тогтвортой хөгжлийг хангах хөтөлбөрт нэгдээд байна.

Ногоон алт төслөөс үндэсний байгууллагуудтай хамтран гаргасан Монгол орны бэлчээрийн төлөв байдлын үндэсний тайланг эцэслэн танилцуулж, байгалийн бүс бүслүүрээр бэлчээрийн доройтол, төлөв байдлын өөрчлөлтийг боловсруулан, бэлчээрийн талхагдлаас сэргийлэх арга замыг тодорхойлсон юм. Уг тайлангаас үзэхэд нийт бэлчээрийн 65 хувь нь анхны төлөв байдлаасаа өөрчлөгдөн доройтсон болохыг харуулж, нэн даруй арга хэмжээ авахгүй тохиолдолд цаашид цөлжих аюул нүүрлэж буйг харууллаа. Монгол улсын Засгийн газар малчидтай хийх бэлчээр ашиглалтын гэрээний тухай заалтыг шинээр боловсруулсан Бэлчээрийн тухай хуулийн төсөлд оруулж 2015 оны аравдугаар сард УИХ-д өргөн барив.

Аймгийн Бэлчээр ашиглагчдын холбоодын санаачлагаар Үндэсний бэлчээр ашиглагчдын холбоо байгуулагдав. Тус холбоо нь цаашид бэлчээрийн зохистой ашиглалтын талаарх

туршлага, үйл ажиллагааг Засгийн газрын бодлоготой уялдуулахад анхааран ажиллах юм. Ногоон алт төсөл нь 2015 оны Миланы Экспо үзэсгэлэнд оролцсон 756 төсөл дотроос байгалийн нөөцийн тогтвортой менежментийн тэргүүн туршлагын шагналыг хүртсэн нь тус төслийн ажлыг маш өндөр түвшинд үнэлсний илрэл боллоо.

2015 онд мал аж ахуйн салбарт гарсан бас нэгэн чухал ахиц дэвшил нь Хүнс Хөдөө аж ахуйн яамнаас УИХ-д “Мал, амьтны эрүүл мэндийн тухай” хуулийн төслийг өргөн барьсан явдал юм. Малаас хүнд халдварладаг бруцеллез болон олон улсын худалдаанд сөргөөр нөлөөлдөг шүлхий өвчинтэй тэмцэх үндэсний стратегийг Монгол улсын Засгийн газраас боловсруулж, улмаар хэрэгжүүлэлтэд нь онцгой анхааран ажиллаж байна. Энэ нь Монгол улс хөрш зэргэлдээ Орос, Хятад улс болон олон улсын зах зээлд мал, малын гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхийг зорьж буйг харуулж байна.

## **Хөдөлмөрийн бүтээмж: Малчид, тариаланчдын хөдөлмөрийн бүтээмж дээшлүүлэх нь**

2014 онд Монгол улсын төмсний бүх талбайд ШХА-ийн санхүүжилттай Монгол төмс төслийн хүрээнд нэвтрүүлсэн чанартай, шинэ сортын үрээр тариалалт хийлээ. Харин 2013 онд энэ тоо 81 хувьтай байжээ. 2014 оны төмсний ургац цаг агаарын хүнд нөхцлийг үл харгалзан 12 тонн/га<sup>1</sup> буюу 2013 оныхтой ижил тогтвортой түвшинд байлаа.

Улсын сорт сорилтын комисс нь 2015 онд дөрвөн хүнсний ногооны сортыг шинээр баталсан ба анх удаа байцаа, лууван, сонгино, манжин гэх мэт үндсэн ногооны 10 гаруй ирээдүйтэй эрлийз сортыг баталлаа. ШХА тус салбарт дэмжлэг үзүүлж эхэлснээс хойш нийтдээ 23 шинэ хүнсний ногооны сортыг батлаад байна.

## **Зах зээлийн боломж: Малчид, тариаланчдын зах зээлд нэвтрэх боломжийг нэмэгдүүлэх нь**

2015 онд Ногоон алт төслийн дэмжлэгтэйгээр малчдын 60 гаруй хоршоо дотоодын боловсруулах үйлдвэрүүдтэй түүхий эд

<sup>1</sup> ШХА-ийн стратегийн хяналт үнэлгээний тайлан, 2015

**МАЛЧДЫН ХОРШООД**

Ногоон алт төслийн дэмжлэгтэйгээр байгуулагдсан **60** гаруй хоршоод: **2015** онд

Мах боловсруулах үйлдвэрүүдэд **45.000** толгой малын махыг нийт **3.4** тэрбум төгрөгөөр нийлүүлжээ

Ноос боловсруулах үйлдвэрүүдэд нийт **1200** кг дээр зэргийн чанартай торомны сэвлэгийг самнан нийлүүлжээ.

Гишүүддээ тараасан ноогдол ашиг **267** сая буюу **2014** оныхоос **32%** өссөн байна.

Нийт хувь нийлүүлсэн хамтын хөрөнгийн өсөлт: **2014** он **1,1** саяТ **2015** он **1,4** саяТ



нийлүүлэх гэрээ байгуулан ажиллаж эхэллээ. Ингэснээр зах зээлд бүтээгдэхүүнээ борлуулах шинэ гарц тэдэнд бий болж байна.


Эрт ургацын технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлснээр дотооддоо үйлдвэрлэсэн төмсний эхний ургацыг долдугаар сарын эхээр хураан авсан нь ердийн хугацаанаас даруй 20 хоногийн өмнө байлаа. Зоорины нөхцлийг сайжруулан, тоо хэмжээг нэмэгдүүлж, урт хугацаанд эрүүл хадгалсан төмсний ач холбогдлыг зах зээлд сурталчилсаны үр дүнд тариаланчдын гар дээрээсээ борлуулах төмсний үнэ улирлын турш жигд өндөр (килограм нь 1,000-1,200 төгрөг) байсан.

**Амьжиргаа: Малчид, тариаланчдын амьжиргааны тогтвортой байдлыг дээшлүүлэх нь**

Бэлчээр ашиглагчдын хэсгүүд малчдын дундын санг тус бүрдээ бий болгож нийт 1,6 тэрбум төгрөгийн бичил зээл олгожээ. Энэ нь 15,000 малчин өрхийн эрүүл мэндийн зардал, хоол

хүнс, хүүхдийн боловсрол, тээвэр, өвс тэжээл худалдан авах зэрэг зайлшгүй хэрэгцээтэй бэлэн мөнгөний дутагдлыг нөхөж, амьжиргааны аюулгүй байдлыг дэмжихэд эерэг нөлөө үзүүлсэн байна. 2015 оны намраас томоохон банкууд бичил зээл олгохоо зогсоосон. Тиймээс дээрх дундын сангуудаас олгосон бичил зээл ялангуяа цөөн тооны малтай ядуу малчин өрхүүдэд нэн чухал ач холбогдолтой болсон.

Малчдын хандлага малын тооноос илүү чанарт анхаарах нь илүү болжээ. Ногоон алт төслөөс бэлчээр ашиглалтын гэрээний илүү нарийвчилсан нөхцөлтэй тухайлбал малын тоог цөөлөх замаар бэлчээрийн төлөв байдал, доройтлыг бууруулах шинэ хувилбарыг найман сумын засаг даргын тамгын газартай хамтран туршлаа. Энэ туршилтаар 18 БАХ-ын малчид малын тоо толгойгоо жил бүр 5-8 хувиар бууруулах замаар 10-15 жилийн туршид малын тоог бэлчээрийн даацад тохируулах гэрээ байгуулав.





# Жендерийн дуран – Фото өгүүлэл

## Малчдын тэргүүн туршлагыг хотноос хотонд дэлгэрүүлэхэд мэдээлийн технологийг ашигласан нь

Б. Түвшинтунгалаг

Ховд аймгийн Цэцэг сумын Бэлчээр ашиглагчдын холбооны тэргүүн Б. Удвал Бэлчээр ашиглагчдын холбооны тэргүүнүүдийн



Б. Удвал (зүүн гар талаас хоёрдахь нь) малчидтай хамтран видео бичлэг хийж байгаа нь

доторх цөөхөн эмэгтэй удирдагчдын нэг. Удвал сумандаа бэлчээрийн доройтлоос сэргийлэх, бэлчээр усаа хамгаалах хамтын менежментийг бий болгохыг зорьж буй малчдын өөрөө удирдах байгууллагыг тэргүүлж байна.

Харин сүүлийн үед тэрээр энэ ажилдаа видео камер ашиглаж, малчдаас гарч буй аливаа сайн санаачлага, туршлагыг дүрс бичлэгээр баримтжуулаад бусадтай нь хуваалцдаг боллоо. Тэрбээр, Швейцарийн хөгжлийн агентлагийн Ногоон алт төсөл, Австралийн Кюэнсландын их сургуулиас хамтран зохион байгуулсан хамтын оролцооны видео сургалтаас энэхүү шинэ чадварыг эзэмшсэн ажээ.

Хамтын оролцооны видео гэдэг нь тэр бүр хурал цугларалтад оролцох боломжгүй зав

чөлөө муутай, алслагдсан малчдад санал бодлоо илэрхийлэх, сайн туршлага, тулгамдсан асуудлаа хуваалцах боломжийг олгож буй мэдээллийг түгээх үр дүнтэй хэрэгсэл юм.

Тус суман дахь “Зайсан” Бэлчээр ашиглагчдын хэсэг (БАХ)-ийн малчид хөдөлмөрөө хоршиж, өөрсдийн нөөц бололцоогоо дайчлан нэгнийхээ малын өвлийн хашаа бууцыг сэргээн засварласан тухай таатай мэдээг тэрээр хүлээн авчээ. Намар нэлээд хэвийсэн, жихүүн салхитай нэгэн өдөр Зайсан БАХ-ын малчидтай уулзаж, энэхүү сайн туршлагыг баримтжуулж, бусад хэсгийн малчдад үзүүлж танилцуулахаар Удвал камертайгаа Зайсан багийг зорьсон юм.

Өвлийн хашаан дээрээ цугласан хэсэг малчид даруй видео бичлэг хийхэд бэлтгэж, хэрхэн хамтран ажилласнаа зургаар дүрсэллээ. Тэдний гаргасан зургийн дагуу Удвал бичлэгээ хийгээд зарим малчдын сэтгэгдэл, ярилцлага зэргээр нэмж баяжууллаа.

Зайсан БАХ-ын малчдын бүтээсэн ажлыг дүрсжүүлж дуусаад, Удвал маань тэндээс 90 км зайтай дараагийн баг руу мэдээлэл түгээхээр явлаа. Тэр оройдоо өдөр нь бичсэн бичлэгээ цэгцэлж эвлүүлээд дараагийн багийн малчдад үзүүлэхэд бэлэн болголоо.

Маргааш өглөө нь ШХА-ийн Ногоон Алт төслөөс хэрэгжүүлж буй бэлчээрийн менежмент, хамтын ажиллагааны талаар мэдээлэл багатай, Бэлчээр ашиглагчдын холбоонд нэгдээгүй малчидтай уулзсан юм.

Хөрш багийн малчид хамтран дулаан өвөлжөө барьсан туршлагыг харуулсан таван минутын богино хэмжээний кино малчдын анхаарлыг ихэд татлаа. Ялангуяа бүлэг хэсгээрээ нийлж хийсэн тэдний бодит ажлыг хараад урамшсан тэд ч бас ингэж хамтаараа хийж болох юм гэж өөр хоорондоо ярилцаж байгаа сонсогдлоо.

Б.Удвал бэлчээрийн зохистой менежментийн аливаа сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэхээр малчдын байгууллагаа улам бэхжүүлэхийн төлөө ажиллана. Харин одоо тэр камер гэдэг нэгэн сайн туслахтай болжээ.

## Мэргэжлийн боловсрол, сургалт (МБС)



Швейцарийн хөгжлийн агентлаг нь Монгол улсын хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн ур чадвартай боловсон хүчин бэлтгэхэд нь мэргэжлийн боловсрол сургалтын салбарт дэмжлэг үзүүлж буй хандивлагчдын нэг юм. ШХА нь Мэргэжлийн боловсрол сургалт, Мэргэжлийн ур чадвар хөгжүүлэх гэсэн хоёр томоохон төсөл хэрэгжүүлж байна.



# Хөтөлбөрийн үр дүн



Сүүлийн жилүүдэд МСҮТ-д суралцах хүсэлтэй залуучууд нэмэгдэж байна.

Хөдөлмөрийн яам нь мэргэжлийн боловсролын салбарыг хөгжүүлэх, түншүүдийн хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах чиглэлээр голлох үүрэг гүйцэтгэж байна. 2015 онд Хөдөлмөрийн яам болон Мэргэжлийн боловсрол, сургалтын түншлэл (МБСТ) ТББ хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурав. Энэхүү санамж бичгийн хүрээнд МБСТ нь тус яамны гадаад түншүүдтэй харилцах харилцааг зохицуулж, мэдлэгийн менежментийн явц, үйл ажиллагааг дэмжин ажилласан. Тус байгууллага нь ШХА, Германы Хамтын ажиллагааны нийгэмлэг, Оюу Толгой ХХК, Ажил олгогчдын холбоо, Барилгачдын холбоо зэрэг хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран Хөдөлмөрийн яамны удирдлаган дор 2015 оны Дэлхийн ур чадварын тэмцээнд оролцсон Монголын багийн Ерөнхий нарийн бичгийн даргын үүргийг амжилттай гүйцэтгэсэн юм.

## **МБС-т хамрагдсан залуусын хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх нь**

Баруун бүсийн МБС-ын сургуулиудад үзүүлж буй дэмжлэгийн хүрээнд төслөөс зохион байгуулсан урт, богино хугацааны мэргэжлийн ур чадвар олгох сургалтанд хамрагдсан зорилтот зургаан сургуулийн төгсөгчдийн 60-аас илүү хувь нь ажлын байртай болсон байна. Энэ нь улсын болон бүсийн дундажтай харьцуулахад харьцангуй өндөр үзүүлэлт аж. Улсын хэмжээний МБС-ын байгууллагуудын бүх төгсөгчдийн ажлын байраар хангагдсан үзүүлэлт 2014-2015 оны хичээлийн жилд улсын

ШХА-ийн МБС төсөл нь Баруун бүсийн 6 сургууль дээр хэрэгжиж байна.

Зорилтот 6 МСҮТ-ийн төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт

2014 - 2015



Баруун бүсийн 6 МСҮТ-ийг нийт **2874** оюутан төгссөн.

Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт, улсын дундажтай харьцуулбал:



63% ажилтай




48% ажилтай

Зорилтот 6 сургуулийн төгсөгчид

Нийт МСҮТ төгсөгчид (Улсын дундаж)

2874 төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт, хүйсээр:



1367

1507

Эмэгтэй төгсөгчдийн 42% ажилтай

Эрэгтэй төгсөгчдийн 74% ажилтай



нийт дүнгээр 48 хувьтай байхад баруун бүсийн дундаж 56 хувь байна.

Иргэдийн дунд мэргэжлийн ур чадвараа хөгжүүлэх сонирхол болоод МБС-ын талаарх үнэлэмж өндөр хэвээр байна. Швейцарийн хөгжлийн агентлагийн мониторингийн судалгаанд хамрагдсан насанд хүрэгчдийн 57-гоос илүү хувь, залуучуудын 59 хувь нь уг салбарын талаар эерэг бодолтой байж, залуусын 91 хувь нь мэргэжлийн ур чадвараа хөгжүүлэх сонирхолтой байгаагаа илэрхийлсэн аж.

Баруун бүсийн МБС-ын төслийн нэвтрүүлсэн Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр болон Ажил мэргэжлийн лавлах боловсруулах арга зүйг үндэсний хэмжээнд хэлэлцлээ. МБС-ын төслийн дэмжлэгтэйгээр боловсруулсан Сургалтын хөтөлбөрийн загвар, Ажил мэргэжлийн лавлах боловсруулах аргачлалыг Хөдөлмөрийн яам эцэслэн баталсан ба удахгүй орон даяар нэвтрүүлэхээр боллоо.

#### ***Мэргэжлийн богино хугацааны сурталтанд хамрагдсан иргэдийн хөдөлмөр эрхлэх ур чадварыг нэмэгдүүлэх нь***

Социалист нийгмийн үед мэргэжил эзэмшсэн, өдгөө ажилгүй иргэдийн дунд ур чадварын богино хугацааны сургалт илүү эрэлттэй байна. МБС-ын түнш байгууллагууд барилга, авто механикийн чиглэлээр ур чадвар олгох богино хугацааны сургалтыг 67 удаа зохион байгуулсан. Тэдгээрийг төгсөгчдийн 62 хувь нь сургалт дууссанаас хойш гурван сарын дотор ажлын байртай болжээ.

Мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээний чанарыг сайжруулж, холбогдох

ажилтнуудыг мэргэшүүлснээр МБС сургуулиуд, орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн газрууд нь эрэлтэд нийцсэн үйлчилгээ, зөвлөгөөг залуучууд, насанд хүрэгчдэд өгөх чадвартай болсон. Зөвлөгөө, үйлчилгээ хүртэгсдийн 75 хувь нь (үүний 54 хувь нь эмэгтэй) мэргэжлээ сонгож, зөв шийдвэр гаргахад эергээр нөлөөлсөн гэжээ.

#### ***Залуучуудын хөгжил: Амьдрах ухаанд суралцахуй***

Залуучуудын хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд нэвтрүүлсэн амьдрах ухааны боловсролыг 2015 оны хичээлийн жилд Ерөнхий боловсролын бүх дунд сургуульд зааж эхэллээ. Сургалтын хөтөлбөрт "Амьдрах ухаанд суралцахуй" гэсэн бие даасан хичээл багтсан. Мөн бусад бүх хичээлийн сургалтын хөтөлбөрийн агуулгад шинэчилсэн арга зүйн дагуу амьдрах ухааны сургалтуудыг багтаахаар боллоо.

Залуучуудын хөгжлийн хөтөлбөр нь өнгөрсөн хоёр жилийн хугацаанд залууст амьдрах ухааны боловсролыг түгээх бүтцийг бий болгоход түлхүү анхаарч ажилласан бол 2015 онд тэрхүү бий болгосон бүтцийнхээ үйл ажиллагааг идэвхжүүлж, тогтворжуулахад гол анхаарлаа хандуулан ажиллаж байна.

Залууст зориулсан эмнэлгүүдийн үйл ажиллагаа жигдэрч, тогтворжлоо. Эрүүл мэнд спортын яам, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран, зорилтод бүсүүдэд залууст ээлтэй долоон эмнэлгийг байгуулсан нь хоёр ба гуравдугаар түвшний эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж байна. Өнгөрсөн жил дээрх эмнэлгүүдээр 39,000 гаруй залуус үйлчлүүлжээ.



Залуучуудын хөгжлийн төвүүд залууст нөөц боломжоо нээхэд нь тусалж байна.



# Жендерийн дуран – Фото өгүүлэл

## Ж. Энхчимэг: Би өөрийнхөө компанийг байгуулна

Б. Золбаатар



Монгол ур чадвар 2013 тэмцээнд Ж. Энхчимэг 3-р байр эзэлснээс хойш жил бүр амжилтаа ахиулж байв

Ж. Энхчимэг эрчүүдийн гэсэн тодотголтой мэргэжлийн салбарт хүйсийн талаарх тогтсон уламжлалт ойлголтыг өөрчилж чадлаа.

Тэрээр ээжийнхээ мэргэжлийг өвлөх зорилгоор өрөг угсрагчийн мэргэжлийг сонгон суралцаж үндэсний болон олон улсын түвшинд өндөр амжилтуудыг гаргасан.

Ж. Энхчимэг Бразили улсын Сан Пауло хотод болсон “Дэлхийн ур чадвар” мэргэжлийн ур чадварын олон улсын уралдаанд өрөг угсралтын төрлөөр орсон монголын анхны эмэгтэй болж түүхэнд нэрээ үлдээлээ.

Тэрээр, 2015 онд “Монгол ур чадвар” тэмцээнд түрүүлж, “Дэлхийн ур чадвар” тэмцээнд орох эрхийг авсан. Монгол ур чадвар тэмцээнд гурван удаа оролцохдоо 2013 онд 3-р байр, 2014 онд 2-р байрыг тэрээр тус тус эзэлж байжээ.

“Миний ээж өрөг угсрагч мэргэжилтэй. Энэ мэргэжлийг хүүхэд байхаасаа л би сайн мэддэг. Барилгыг хэрхэн барьдаг нь надад маш гайхалтай байдаг. Би ирээдүйд өөрийн гэсэн барилгын компаниа байгуулахыг мөрөөдөж байна” хэмээн Ж. Энхчимэг хэллээ.

“Мэргэжлийн мэдлэгээс гадна хичээл зүтгэл, тэсвэр тэвчээр бол түүний амжилтын нууц юм” гэж багш нь Ж. Энхчимэгийн ур чадварыг тодорхойлдог юм.



Ж. Энхчимэг Дэлхийн ур чадвар тэмцээнд өрөг угсралтын төрлөөр оролцсон анхны монгол эмэгтэй болж түүхэнд нэрээ үлдээлээ



## Захиргааны шинэтгэл, орон нутгийн засаглал, иргэдийн оролцоо



Засгийн газар төвлөрлийг сааруулж, сайн засаглалыг бэхжүүлэхээр дэвшүүлсэн зорилтын хүрээнд хэд хэдэн чухал хууль батлуулсан нь Монгол улс захиргааны болон төсвийн төвлөрлийг сааруулах талаар хийсэн томоохон алхам боллоо. Засгийн газрын энэхүү зорилгыг Швейцарь Улс дэмжиж, ардчиллыг бэхжүүлж, төвлөрлийг сааруулах туршлагаасаа хуваалцаж байна.

# Хөтөлбөрийн үр дүн



Орон нутагт шийдвэр гаргах үйл явцад иргэд улам идэвхтэй оролцож, санал бодлоо илэрхийлдэг болж байна. Ховд аймгийн Иргэний танхимд болж буй хурал.

## **Орон нутгийн засаглал: Орон нутгийн засаглалын үйл ажиллагаа, хариуцан тайлагнах тогтолцоог сайжруулах нь**

Орон даяар байгуулагдсан Нэг цонхны үйлчилгээний (НЦҮ) төвийн үр дүнд төрийн үйлчилгээний хүртээмж, чанар, үр нөлөө тогтмол сайжирч байна. Орон нутгийн удирдлага төсөв хөрөнгөөрөө 152 НЦҮ төвийг байгуулжээ. Судалгааны дүнгээс харахад НЦҮ-ний төвөөр үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж 76-80 хувь болж өсчээ.

Засаглалыг дэмжих, төвлөрлийг сааруулах хөтөлбөрийн үр дүнд орон нутгийн түвшинд шийдвэр гаргах явц илүү иргэдийн оролцоотой, ил тод боллоо. Тухайлбал, орон нутгийн хөгжлийн сан (ОНХС)-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг тодорхойлох 173 удаагийн хэлэлцүүлэгт 16,800 гаруй иргэд оролцжээ. Тэдний 56 хувь нь эмэгтэйчүүд юм. Ийнхүү иргэдийн оролцоо нэмэгдсэнээр нутгийн удирдлагын байгууллагуудын үйл ажиллагаа илүү ил тод болж байна.

Бүх сумдад орон нутгийн түвшинд шийдвэр гаргахад иргэдийг оролцуулснаар ил тод байдал болон хариуцан тайлагнах явц сайжирч байна. Нийт 14 сум, гурван хороонд Орон нутгийн түвшинд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх төсөл хэрэгжсэнээр олон нийтийн хурал, цуглаанд

оролцох иргэдийн ирц 13.9 хувиар нэмэгдэн, сэтгэл ханамжийн түвшин нь 50 хувиас 60 хувь болж өссөн.

УИХ-д өргөн барьж буй аливаа хуулийн төслийн санаачлагад иргэдийн оролцоог хангахыг баталгаажуулсан Хууль тогтоомжийн тухай хууль 2015 онд батлагдлаа. Үүнд Швейцарийн хөгжлийн агентлагаас үзүүлсэн техникийн туслалцаа томоохон хувь нэмэр оруулсан юм. Төвлөрлийг сааруулах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх бодлого, эрх зүйн орчны суурь үндсийг бий болгоход Засаглалыг дэмжих, төвлөрлийг сааруулах хөтөлбөр (ЗДТС)-өөс бодлогын судалгаа болон хэлэлцүүлгийг зохион байгуулан дэмжлэг үзүүлж ажиллав.

ЗДТС хөтөлбөр бодлогын хэлэлцүүлгийг амжилттай зохион байгуулснаар УИХ-ын Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн талаарх шийдвэрт нөлөөлөв. Хуулийн нэмэлт өөрчлөлтүүд нь өрсөлдөөнийг хязгаарлаж, орон нутгийн худалдан авах ажиллагааны нэгжүүдийг татан буулгаснаар худалдан авалтын эрх зүйн орчинд таагүй нөлөө үзүүлэх байв.

Орон нутгийн худалдан авах ажиллагааг 13 аймагт үр дүнтэй зохион байгуулж, тэдгээрийн гүйцэтгэлд иргэний нийгмийн байгууллагууд (ИНБ) хяналт тавьж ажиллалаа. Ингэснээр нийтийн хөрөнгийг ил тод, үр дүнтэй, ашигтайгаар зарцуулах орон нутгийн худалдан авах ажиллагааны чадавхи бэхжсэн. Тендерийн цахим хуудсыг найман аймаг тогтмол ажиллуулснаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх болон олон нийтэд мэдээлэл түгээх байнгын тогтолцоо бий болов.

ИНБ-ууд нийтдээ 38 барилга байгууламжийн гэрээний хэрэгжилтэд хяналт тавьснаар техникийн тодорхойлолтод нийцээгүй барилгын материал ашигласан зэрэг олон зөрчлийг илрүүлжээ. Гэрээний үүргээ зөрчсөн гүйцэтгэгчид иргэдийн шаардлагаар зөрчлөө арилгасан. Эдгээр мэдээллийг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр өргөнөөр мэдээлсэн.



Дэлхийн банкны үнэлгээгээр Монгол улсын төсөв санхүүгийн ил тод байдал, төрийн санхүүгийн удирдлага орон нутгийн түвшинд сайжирсан байна<sup>2</sup>. Орон нутгийн төрийн худалдан авах ажиллагаа 13 аймгийн 26 суманд илүү ил тод, хариуцлагатай зохион байгуулагдав.

***Иргэний нийгмийн хөгжил: Иргэний нийгмийн байгууллагуудын чадавхи, нийгмийн хариуцлагыг сайжруулах нь***

Орон нутгийн сургагч багш нарын үндэсний сүлжээ бий болсноор орон нутгийн чадавхийг бэхжүүлэхэд дэмжлэг боллоо. Орон нутгийн

хөгжлийн хүрээлэн ТББ байгуулагдаж, улсын хэмжээнд нийт 52 сургагч багш бэлтгэсэний 17 нь эмэгтэйчүүд байна.

Орон нутгийн түвшинд иргэдийн оролцоог дэмжих төсөл хэрэгжсэн 17 сум, хороодод “иргэдийн онооны карт” санаачлагыг хэрэгжүүлснээр анхан шатны эрүүл мэнд, сургууль, цэцэрлэг, нийгмийн халамж үйлчилгээний чанар болон ОНХС-гийн төлөвлөлт сайжирлаа. Мөн энэхүү санаачлагын үр дүнд иргэдийн оролцоо нэмэгдэн, төрийн ажилтнуудын иргэдтэй харилцах харилцаа сайжирч буй зэрэг өөрчлөлтүүд гарч байна.



Орон нутгийн хөгжлийн хөрөнгө оруулалтын төслийг иргэдийн оролцоотойгоор сонгох, эрэмблэх олон нийтийн хэлэлцүүлгүүд амжилттай өрнөж байна. Орон нутагт иргэд зам барих, хотын гудамжны гэрэлтүүлэг, ногоон байгууламж зэрэг хөгжлийн төслүүдэд хөрөнгө оруулахыг голчлон дэмжсэн байна.

<sup>2</sup> Монголын төсвийн зарцуулалт, санхүүгийн ил тод байдлын тайлан (PEFA), Дэлхийн банк, 2015 оны 4 дүгээр сар



# Жендерийн дуран – Фото өгүүлэл

## Иргэдийн дуу хоолой болсон төлөөлөгч эмэгтэй

Филип Лонг

Д. Бэрцэцэг багш их сургуулиа дүүргэснээс хойш төрөлх Зуунмод хотдоо боловсролын салбарт 30 гаруй жил ажиллажээ. “Би Зуунмод хотынхоо ирээдүй хойч үеийг сурган хүмүүжүүлэхэд хувь нэмрээ оруулахаар ирсэн” гэж тэрбээр дурсан өгүүлэв. Өдгөө Зуунмод хот 4600 гаруй өрхийн нийт 16 мянга гаруй хүн амтай.

1990-ээд оноос эхэлсэн ардчилсан хувьсгалын үед Д. Бэрцэцэг улс төрд татагдан орсон. Сонгуулийн сурталчилгааны менежерээс эхлэн орон нутгийн сонгуульд хоёр ч удаа нэр дэвшсэний эцэст тэрбээр 2012 онд анх Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал (ИТХ)-д сонгогджээ.

Сонгогдсоныхоо дараахан тэрбээр ИТХ-ын бүх төлөөлөгчдийн чадавхийг дээшлүүлэх чиглэлээр НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөр болон Швейцарийн хөгжлийн агентлагаас хамтран хэрэгжүүлж буй Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх төслийн Үндэсний сургалтад хамрагдав. Уг сургалтаар шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, төсвийн менежмент, төлөөлөгчийн

ёс зүй, ногоон хөгжил, хүний эрх, жендер зэрэг олон талын мэдлэг мэдээлэлтэй болжээ.

Мөн төслөөс үндэсний хэмжээнд зохион байгуулсан Эмэгтэй манлайлагчдын сургалтанд хамрагджээ. “Зуунмод сумын ИТХ-д сонгогдсон 14 эмэгтэй төлөөлөгчдийн нэг болохоор энэ сургалт надад маш олон талаар нөлөөлсөн” гэж Бэрцэцэг онцоллоо.

Уг сургалтаар Иргэдийн хурлын бүх эмэгтэй төлөөлөгчдийг манлайлал, эрх мэдлийн хүч, хүний эрх зэрэг чиглэлээр сургаж, чадавхжуулж байна.

Ийм сургалтуудаар эмэгтэй төлөөлөгчдийг дэмжсээр байгаасай гэж хүсч байна гэж Бэрцэцэг хэлэв. “Эмэгтэйчүүд болон гэр бүл, нийгмийн гол тулгуур багана. Удирдлагын түвшинд эмэгтэйчүүд олноороо гарч ирэх тусам эв нэгдэл, үр бүтээл нэмэгдэж, зөрчил хохирол бага байх болно” гэлээ.

Бэрцэцэгийн хувьд хариуцлагатай удирдагч байна гэдэг нь орон нутгийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад иргэдийн дуу хоолой болж, илүү сайхан ирээдүйг байгуулна хэмээн үзэж байна.

Зуунмод сумын ИТХ-ын дарга Д. Бэрцэцэг (зүүн гар талаас) залуучуудыг сайн дурын үйлсэд уриалан оролцуулж, орон нутгийн шийдвэр гаргах үйл явцад тэднийг идэвхтэй оролцоогыг дэмждэг.



## Бичил уурхайн салбарт



2015 онд Тогтвортой бичил уурхай төсөл нь төрийн албан хаагчид (үүрэг хүлээгчид) болон бичил уурхайчидтай (эрх эдлэгчид) хамтран ажилласны үр дүнд олон эерэг үр дүн гарлаа. Тухайлбал, бичил уурхайн үйл ажиллагаа албажих үйл явц эрчимжиж тэдгээрийн амьжиргаа дээшилсний зэрэгцээ хүний эрхийн нөхцөл байдал сайжирсан байна.



# Хөтөлбөрийн үр дүн



Баянхонгор аймаг дахь Хувиараа ашигт малтмал олборлогчдыг дэмжих холбоо ТББ нь Шударга олборлолтын гэрчилгээ хүртсэн Азийн анхны бичил уурхайчдын байгууллага боллоо.

Монгол улсад хүний эрхийн конвенцийн хэрэгжилтэд өндөр түвшний үнэлгээ хийсэн нь Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоонд бичил уурхайчдын эрхийг хамгаалах нөлөөллийн ажиллагаа явуулах таатай боломж олгов. Тус холбоо нь НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхийн дүгнэлт хэлэлцүүлэг болон НҮБ-ын Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай Пактын хороонд Монголын бичил уурхайчдын эрхийн талаар тайлан, мэдээлэл хүргүүлсэн. Эдгээр хүний эрхийг хамгаалах механизмын тусалцаатайгаар бичил уурхайг албажуулах, эрх зүйн орчныг сайжруулах, бичил уурхайн ажиллагаанд мөнгөн усны хэрэглээг багасгах тухай Минаматагийн конвенцийг хэрэгжүүлэх, хүүхдийг бичил уурхай дахь хөдөлмөрөөс хөндийрүүлэх зэрэг асуудлыг тусгасан зөвлөмжүүдийг Монгол Улсын Засгийн газарт өгсөн. Эдгээр зөвлөмжийг Монгол улсын Засгийн газар хүлээн авч, хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулаад байна.

ШХА-ийн Монгол Улсад бичил уурхайн дэд салбарт үзүүлсэн дэмжлэгийн үр нөлөө нь дэлхийн түвшинд үнэлэгдэж байна. Энэ тухай бичил уурхайн талаарх олон улсын бодлогын хэлэлцүүлгийн үеэр онцлон тэмдэглэж, улмаар Монгол Улсыг бичил уурхайн мэдлэг, туршлага солилцох төв хэмээн олон улсад танилцууллаа. Үүний үр дүнд Танзани, Этиоп, Зимбабве, Колумб зэрэг орон хөгжиж буй улсуудын хооронд Өмнөд-өмнөдийн хамтын ажиллагааг бэхжүүлж, туршлага солилцох сонирхлоо илэрхийлээд байгаагийн зэрэгцээ Монголын

бичил уурхайн мэдлэгийн төвөөс томоохон хүлээлттэй байгаа. Байгаль орчин, хөгжлийн олон улсын хүрээлэн Монгол улсыг дэлхийн бичил уурхайн хэлэлцүүлгийн зөвлөх бүлэгтээ оруулсан. Энэ нь олон улсын бичил уурхайн бодлогын хэлэлцүүлэгт ШХА-ийн дэмжлэг, манлайллыг хүлээн зөвшөөрч байгааг нотолж байна.

Азийн сангаас хэрэгжүүлж буй “Байгаль орчныг хамгаалахад талуудын оролцоог нэмэгдүүлэх нь II” төслийн хүрээнд 2014-2015 онд гар аргаар ашигт малтмал олборлосоны улмаас эвдэрч, орхигдсон нийт 144 га газарт Бичил уурхайн нөхөн сэргээлтийн 17 төслийг загвар болгон хэрэгжүүллээ. Энэхүү нөхөн сэргээлт нь эдийн засгийн хувьд хэмнэлттэй, байгаль экологид ээлтэй, олон нийт хүлээн зөвшөөрөхүйц байдгаараа онцлог юм. Гарсан үр дүн, туршлага дээр үндэслэн Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалыг боловсруулан хэлэлцүүлж, “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын шинэчилсэн хувилбарын хавсралт болгон батлуулахаар бэлтгээд байна.

2015 онд Хөдөлмөрийн яам, Эрүүл мэнд, спортын яамнаас зохион байгуулалтанд орсон бичил уурхайчдад чиглэсэн тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. 2015 онд нийт 1367 уурхайчин (57 хувь нь эмэгтэй) төрийн санхүүжилттэй эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан байна.

2015 оны нэгдүгээр сард Баянхонгор аймаг дахь бичил уурхай эрхлэгчдийн Хувиараа ашигт малтмал олборлогчдыг дэмжих холбоо ТББ байгаль орчинд ээлтэй, аюулгүй уурхай эрхэлж байгаагаа баталгаажуулж Шударга олборлолтын гэрчилгээ хүртсэн Азийн анхны бичил уурхайчдын байгууллага боллоо. Дэлхий дахинд хүлээн зөвшөөрөгдсөн Шударга олборлолтын стандартын дагуу тус ТББ-ын уурхайчид жилдээ 36 кг алт олборлох боломжтой. Энэ нь Тогтвортой бичил уурхай төслөөс тус ТББ-д байгаль орчны стандартаа сайжруулахад нь техникийн болон санхүүгийн тусалцаа үзүүлсний үр дүн юм.

ШХА-ийн дэмжлэгтэйгээр Онцгой байдлын ерөнхий газрын Уул уурхайн аврах алба болон Хөдөлмөрийн яам 8044 уурхайчныг (18 хувь нь эмэгтэй) хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны сургалтанд хамруулсан.




## БИЧИЛ УУРХАЙН БИЧИЛ СТАТИСТИК 2013-2015

Монгол банканд борлуулсан алтны хэмжээ




<sup>1</sup>2015 онд үндэсний хэмжээнд хийгдсэн нийт алтны албан борлуулалтын 46%

Ашигт малтмал ашигласны төлбөр/роялти




Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамрагдсан бичил уурхайчдын тоо



Эмэгтэй

Бичил уурхайн зориулалтаар олгосон газар<sup>2</sup>



<sup>2</sup>Өссөн дүнгээр

# 2016 оны хөтөлбөрийн төлөвлөлт

Швейцарийн хөгжлийн агентлаг нь 2016 онд шинээр хэрэгжих зургаан төсөл болон хэрэгжиж буй төслийн удаах үе шатыг эхлүүлнэ. Швейцарийн хамтын ажиллагааны газар нь төсөл хөтөлбөрийнхөө үйл ажиллагааны хэрэгжилтэд түлхүү анхаарч, төсөл болон салбар чиглэлүүдийн хоорондын уялдаа холбоог сайжруулахад анхаарлаа хандуулна.

ШХА-ийн хөтөлбөрийн бүхий л үйл ажиллагаанд ядуурлыг бууруулах, жендерийн тэгш байдлыг хангах нийтлэг зорилгийг хэвээр хадгална.

2015 оны хоёрдугаар сард Монгол Улсад хэрэгжүүлэх Швейцарийн хамтын ажиллагааны 2013-2016 оны стратегид Дунд хугацааны үнэлгээ хийгдсэн бөгөөд энэхүү стратегийн хугацааг нэг жилээр сунгахыг зөвлөсөн. Ийнхүү хамтын ажиллагааны шинэ стратегийг 2016 оны УИХ-ын сонгуулийн үр дүнд бүрэлдэх шинэ засгийн газар байгуулагдсаны дараа, мөн одоо хэлэлцэж буй Швейцарийн Холбооны Улсын олон улсын хамтын ажиллагааны баримт бичиг

батлагдсаны дараа уялдуулан боловсруулахаар төлөвлөж байна.

2016 оноос эхлэн 2020 оноос хойшхи Швейцарь, Монголын хөгжлийн хамтын ажиллагааг хэрхэн хөгжүүлэх чиглэлээр шинэ арга зүй, шинэлэг талбар, хамтын ажиллагааны бусад хувилбаруудыг судлах болно.

2015 онд ШХА-ийн төсөл хөтөлбөрийн төсвийн дээд хэмжээ оргилдоо хүрч оны эцэс гэхэд нийт 22 сая шв.франк зарцуулсан байв. Харин 2018 оноос төсвийн хэмжээ буурна.

